



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

᠒᠐᠒᠖ оны ᠐5 сарын 13 өдөр

Дугаар ᠕/᠒51

Есөнбулаг сум

Комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэг, Усны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь.

1.Дэлхийн Байгаль Хамгаалах сангийн санхүүжилтээр Баян-Уул сумын Намын худгийн салаа, Чулуутын эх нэртэй газруудад шинээр хөв байгуулсан ажлыг хүлээн авч байнгын ашиглалтад оруулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:	Б.Бямбадорж	(Аймгийн Ерөнхий архитектор
Гишүүн:	С.Жаргалзаяа	Хүйсийн говь Цэцэг нуурын сав газрын захиргааны дарга)
	Г.Лхагвабаатар	(Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын барилгын хяналтын инженер)
	Н.Алтансүх	(Байгаль орчны газрын усны нөөц, ашиглалт, хамгаалалт хариуцсан мэргэжилтэн)
	Б.Золзаяа	(Орон нутгийн өмчийн газрын өмчийн асуудал хариуцсан мэргэжилтэн)
	С.Энхбаяр	(Баян-Уул сумын Засаг дарга)
	О.Мөнхтогтох	(Дэлхийн Байгаль Хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн газрын Алтай Соёны газрын ахлах мэргэжилтэн)
	Б.Сугар	(“Гэгээн Эрдэнийн Очир” ХХК-ийн захирал (гүйцэтгэгч))
Нарийн бичгийн дарга:	Э.Булгантамир	(Хүйсийн говь Цэцэг нуурын сав газрын захиргааны ахлах мэргэжилтэн)

2.Намын худгийн салаа, Чулуутын эхийн хөвийн ажлыг хүлээн авахдаа гэрээнд тусгагдсан ажлын даалгавар, зураг төсвийн дагуу хийгдсэн эсэх болон

холбогдох баримт бичгийн бүрдлийг хүлээн авч, үр дүнг 2026 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор танилцуулахыг комисс (Б.Бямбадорж)-т үүрэг болгосугай.

3.Хөрөнгийг бүртгэж, ашиглалтад хяналт тавьж ажиллахыг орон нутгийн өмчийн газар (Л.Ганхуяг)-т, цаашдын ашиглалт, арчилгаа, хамгаалалтыг хариуцаж ажиллахыг Баян-Уул сум (С.Энхбаяр)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ